



О.БАЯРЖАРГАЛ

*Хууль сахиулахын их сургууль
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Нийгмийн ажлын
тэнхимийн багш, ахлах дэслэгч*

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР ИРСЭН ЯЛТАНД ҮЗҮҮЛЖ БУЙ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн амьдралын явцад зарим хүмүүс гэмт хэрэг үйлдэн шүүхийн шийтгэх тогтоолоор баривчлах болон хорих ял сонсож ялтан болдог. Хорих ангид ирж буй хоригдогчдыг сонголт хийж авах боломжгүй бөгөөд шүүхээр таслагдсан хэнийг ч хүлээн авах үүрэгтэй байдаг. Тэдгээр хүмүүсийн амьдарч байсан орчин нөхцөл, амьдралын хэв маяг, үйлдсэн гэмт хэргийн төрөл, хэлбэр гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөллөөс хамааран хүн бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтой төдийгүй хорих байгууллагад дасан зохицох чадварын хувьд ч харилцан адилгүй байдаг.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлын үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн дараах баримт бичгүүд байдаг. Үүнд: Хорих ангийн дотоод журам, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар, Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр зэрэг бичиг баримтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж ирсэн⁷⁷. Эдгээр нь хорих ангид шинээр ирсэн ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний талаар хэрхэн тусгасныг судлахад шинээр ирсэн ялтанд үзүүлэх мэргэжлийн үйлчилгээ тодорхой боловч шинээр ирсэн ялтнуудын хувьд дараах хүндрэл бэрхшээл байсаар байна.

Хорих байгууллагад шинээр ирсэн ялтны нийгэм, сэтгэл зүйн хувьд илрэх шинж тэмдгүүдийг судалж үзвэл судалгаанд оролцогчдын 59 хувь нь анхаарал төвлөрөхгүй болсон, 53 хувь нь амархан уурлаж бухимдах болсон, 65 хувь нь нойрондоо муу болсон гэж хариулсан байна. Эдгээр шинж тэмдгүүд байнга болон заримдаа илэрдэг гэж талаас илүү хувь хариулснаас

77 ШИШЕГ "Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл" УБ 2014 он

харахад сэтгэл зүйн үйлчилгээ авах хэрэгцээ өндөр байгааг илтгэж байна. Сэтгэл санааны хувьд илрэх шинж тэмдэг ⁷⁸

№	Шинж тэмдэг	байнга	заримдаа	огт үгүй
1.	Нойрондоо муу болсон.	65%	23%	12%
2.	Цочромтгой болсон.	37%	33%	30%
3.	Хий хоосон зүйлд зовинох болсон.	25%	46%	29%
4.	Амархан уурлаж бухимдах болсон.	18%	53%	29%
5.	Ямар ч зүйл хийх сонирхолгүй болсон.	34%	28%	38%
6.	Амархан уйлах болсон.	23%	46%	31%
7.	Анхаарал төвлөрөхгүй болсон.	26%	59%	15%

Шинээр ирсэн ялтанд тулгарч буй дээрх бэрхшээлтэй асуудлыг хэрхэн даван туулдаг талаар судалж үзэхэд тэдний ихэнх (68 хувь) нь ямар ч арга хэмжээ аваагүй буюу хэн нэгнээс дэмжлэг авч чадаагүй, харин үлдсэн хувь нь ар гэрийнхэн, нийгмийн ажилтан, хорих ангийн албан хаагч, ялтнаас тодорхой дэмжлэг туслалцаа авч, даван туулсан байна. Тухайлбал, гэр бүлийнхэн нь эргэлтээр уулзахад дэм өгч, урам хайрлан даван туулахад нь тусалсан бол нийгмийн ажилтны дэмжлэгтэйгээр сэтгэл санаагаа тайвшруулах замаар орчиндоо аажмаар дассан байна.

Харин хэн нэгнээс дэмжлэг аваагүй хүмүүсийн хувьд тэд дараах хариултуудыг өгсөн. Үүнд:

- Тухайн орчиндоо дасан зохицсон, адаптаци явагдах;
- Цаг хугацаа, гэвчээр, сэтгэлийн дэм хэрэгтэй байсан, гэр бүлийнхний хайр халамж үгүйлэгдэж байсан, дасан зохицох шаардлагатай гэдгийг ойлгож гэр бүлийнхнээ л бодож даван гарна гэж бодох;
- Сэтгэл зүйчтэй сайн харилцаж, алба хаагчидтай нээлттэй харилцах;
- Сэтгэл санааны дэмжлэг өгч, зөвлөгөө өгөх туслалцаа зайлшгүй

⁷⁸ О.Мягмар "Хувийн дасан зохицохуй" УБ 2000 он

хэрэгцээ гарч байх;

- Даван туулах ямар ч арга байгааг олж хараагүй, тэвчсэн өөрөө өөрийгөө тайвшруулах арга хэрэглэх;
- Бусдаас хол ихэвчлэн гадаа байж, дүлий сохор хүн шиг бүгдийг өнгөрөөж байсан;
- Одоо ч даван туулж чадаагүй байна, яваандаа дасан зохицоно гэж бодож байгаа гэх мэт

Эдгээр хариултаас харахад шинээр ирсэн ялтан хүндрэл, бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэхийн тулд хэн нэгнээс тусламж дэмжлэг авахыг хүсэж байсан ч авч чадаагүй, тэдэнд албаны зүгээс дэмжлэг үзүүлээгүй бөгөөд өөрөө сэтгэл зүйгээрээ, тэвчээр хатуужил гарган асуудлаа даван туулах гэж оролдсон байна. Зарим нь огт даван туулах чадваргүй байгаа нь харагдаж байна.

Харин тэдэнд шаардлагатай байгаа дэмжлэг туслалцааг авч үзэхэд 6 сарын өмнө ирсэн ялтны хэрэгцээ, сарын өмнө ирсэн ялтны хэрэгцээтэй ижил байгаа нь үйлчилгээ үр дүнтэй хүрч чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.

№	Хорих ангид ирсний дараа танд ямар дэмжлэг туслалцаа хэрэгтэй байсан бэ?	Хорих ангид ирээд хэдэн сар болсон бэ?			
		1-30 хоног	2-3 сар	4-5 сар	6 сар
1	Бусадтай харилцах талаар хэн нэгнээс зөвлөгөө авах	42%	48%	50%	0%
2	Ар гэрийнхэнтэйгээ холбоо барих	38%	35%	40%	11%
3	Эрүүл мэндийн үйлчилгээ авах	25%	9%	15%	0%
4	Хууль эрх зүйн зөвлөгөө авах	8%	0%	10%	0%
5	Хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах	0%	0%	10%	0%
6	Ахуйн болон материаллаг хэрэгцээгээр хангагдах	4%	0%	5%	0%
7	Соёл спортын арга хэмжээнд хамрагдах	33%	17%	10%	74%
8	Ажил хөдөлмөр эрхлэх	25%	9%	15%	0%
9	Дээрх бүгд	8%	17%	5%	0%

Мөн нийгмийн ажилтанд хандсан байдлыг нь авч үзэхэд 76 хувь нь эхний долоо хоногт, 17 хувь нь 2 долоо хоногийн дараа, 3 хувь нь 3-5 долоо хоногийн дараа, 1 хувь нь 5-6 долоо хоногийн дараа, 1 хувь нь 7-8 долоо хоногийн дараа, 2 хувь нь 9 ба түүнээс дээш долоо хоногийн дараа гэсэн хариулт өгсөн байна.

... Шинээр ирсэн ялтнуудыг бүгдийг хамт суулгаж байгаад, эхний 2 долоо хоногийн дотор хорих ангийн дотоод журам, ялтны эрх үүргийн талаар мэдээлэл хийдэг. Түүнээс бичиг нэг нэгээр нь уулзаж, нөхцөл байдлын үнэлгээ хийж ажладаггүй... Нийгмийн ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Судалгаанд оролцсон нийгмийн ажилтны хариултаас харахад 2 хувь нь огт уулзаагүй, 40 хувь нь эхний өдөр уулзсан, 46 хувь нь долоо хоногийн дараа уулзсан, 8 хувь нь 8-14 хоногийн дараа уулзсан, 4 хувь нь 15 дээш хоногийн дараа уулзсан гэж хариулжээ. Нийгмийн ажилтан шинээр ирсэн ялтнуудтай 7 хоногийн дотор нөхцөл байдлын үнэлгээ хийн, шаардлагатай мэдээллийг өгч, цаашид ямар үйлчилгээ үзүүлэх эсэхийг тодорхойлно гэж “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-г тусгасан байна. Гэтэл судалгааны үр дүнгээс харахад нийт хоригдогчдын 50-аас илүү хувь нь эхний 7 хоногт уулздаг гэсэн боловч бусад 24 хувь нь 14 хоногоос хойш уулздаг байна. Нийгмийн ажилтнуудын дийлэнх хувь нь хэдийгээр эхний долоо хоногт шинээр ирсэн ялантай уулздаг хэдий ч дээрх зааварт тусгагдсны дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид үзүүлэх үйлчилгээг тодорхойлохоос илүүтэй зөвхөн хорих ангийн дотоод журам, ялтны эрх үүргийн талаар л мэдээлэл өгдөг болох нь нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын явцад харагдаж байсан. Энэ байдал нь мөн нийгмийн ажилтнуудаас авсан судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, нийгмийн ажилтнуудын 40 хувь нь эхний 7 хоногт, талаас илүү хувь нь 14 хоногтоо болон тэрнээс хойш хугацаанд уулздаг байна.

Мэдээлэл авсан хугацаа болон мэдээллийн ач холбогдлыг авч үзэхэд /хорих ангид дасан зохицоход хэр зэрэг хэрэгтэй эсэхийг/ 4 хувь нь огтхон ч тус болоогүй, 15 хувь нь бага зэрэг тус болсон, 36 хувь нь нэлээд тус болсон, 45 хувь нь маш их тус болсон гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын хариултаас харахад хорих ангийн талаарх болон ялтны эрх үүрэг талаар мэдээлэл хийх нь шинээр ирсэн ялтнуудын хувьд ямар нэгэн байдлаар тус болсон, харин үүнийг нь хэрхэн танилцуулахаас шалтгаалан ялтанд үр дүнтэй эсэх нь тодорхойлогддог байна. Энэ мэт асуудлын улмаас сэтгэл санааны болон бие бялдар, физиологийн хямралтай байдлаа даван туулж чадахгүйгээс ял эдэлж байх хугацаандаа зөрчил, дахин гэмт хэрэг үйлдэх ч тохиолдол гардаг. Иймээс шинээр ирсэн ялтны нийгэм, сэтгэл зүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, бие даан ажиллах чадварт чиглүүлэх зэрэг мэргэжлийн үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай юм.

Шинээр ирсэн ялтнуудын хувьд бие махбодын болон сэтгэл санааны хямрал, хорих ангийн орчин дахь харилцааны асуудал, ар гэртээ санаа зовох зэрэг нэлээдгүй асуудлууд тулгамддаг байна. Тэдний эдгээр асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ хэрэгцээтэй гэдэг нь тодорхой байгаа боловч тэд тус үйлчилгээг хангалттай авч чадахгүй байгаа

нь судалгаанаас ажиглагдаж байна. Тухайлбал, энэ нь хугацааны хувьд анх ирээд 7 хонож байгаа ялтан 6 сар болсон ялтны хувьд шаардлагатай дэмжлэг тусалцаа хэрэгцээ нь ижил байгаагаас харагдаж байна.

Хорих ангийн нийгмийн ажилтнуудын хувьд шинээр ирсэн ялтанг хүлээж авахад оролцох ба эхний долоо хоногт багтаан хорих ангийн дүрэм журам, ялтны эрх үүргийн талаар мэдээлэл өгөх, ар гэртэй нь холбоо бариулж, утсаар яриулахад голлон анхаарч ажиллаж байна. Харин эдгээрээс гадна хоригдогчдод нэн тэргүүний шаардлагатай байгаа тусламж дэмжлэг болох хорих ангийн нөхцөлд хэрхэн бусадтай харилцах талаар зөвлөгөө өгөх, мөн тэднийг судлан, хэрэгцээтэй үйлчилгээг тодорхойлох зэрэг чухал зүйлсэд төдийлөн анхаардаггүй байдал ажиглагдаж байна.

Мөн дээрх баримтаас гадна шинэ ирсэн ялтанг шүүхээр таслах хүртэл бүртгэгдсэн хувийн хэрэг дагаж ирдэг ч нийгмийн ажлын үйлчилгээг хэрхэн авсан талаарх мэдээлэл бүхий кейс файл, ялтны талаарх нийгмийн ажилтнуудын тодорхойлолт дагаж ирдэггүй нь шинэ ирсэн ялтанд маш их асуудал шийдвэрлэгдэхгүй үлдэж байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Учир нь нийгмийн ажилтнуудын ачаалал их байдаг тул ялтан бүрийг шинээр хүлээж авах, мэдээллийг нь бий болгоход хугацаа шаардагдаж байна.

Шинээр ирсэн ялтнууд нь бэрхшээлээ даван туулж чадахгүйн улмаас гэмт хэрэг, зөрчил хорих ангид үүсгэх эсэх нь тэдгээрт чиглэсэн мэргэжлийн үйлчилгээнээс шууд ба шууд бусаар хамааралтай байна. Иймд энэ зорилтот хэсгийн онцлог хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо сиситемийн онолын загварыг ашиглах, тасралтгүй байдлаар нийгмийн ажилтнуудын кейс конференсе, бүлгийн уулзалт зохион байгуулах, нийгмийн ажлын үйлчилгээг хэрхэн авсан талаарх мэдээлэл бүхий кейс файл, ялтны талаарх нийгмийн ажилтнуудын тодорхойлолт хорих байгууллагад л ирэхэд дагалдуулан ирүүлэх зайлшгүй шаардлагатай гэж судлаачийн зүгээс дүгнэлт хийж байна

Ном зүй

1. ИШШГЕГ “Эрх зүйн баримт бичиг” УБ 2014 он
2. О.Мягмар “Хувийн дасан зохицохуй” УБ 2000 он
3. Ш.Ичинхорлоо “Судалгааны ажлын үндэс” УБ 2007 он
4. Каритас Чех ТББ “Хорих байгууллага дахь нийгмийн ажил” УБ 2013 он